Ковид-19 цар тахлын үеийн цахим сургалтын талаарх оюутны өөрийн үнэлгээ ба сэтгэл ханамж

С.Хандмаа[1], Х.Сэр-Од[2], Б.Балжинням[1], С.Гал-Эрдэнэ[1], Б.Жавхлан[3], Д.Нямдорж[4] Г.Батбаатар[5]
[1]Багшийн хөгжил, цахим сургалтын газар, АШУҮИС
[2]Нийгмийн эрүүл мэндийн сургууль, АШУҮИС
[3]Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар, АШУҮИС
[4]Био-Анагаахын сургууль, АШУҮИС
[5]АШУҮИС
khandmaa@mnums.edu.mn

Түлхүүр үг
Хичээлийн хуваарь, хичээлийн агуулга, хичээлийн материал

Товч утга
КОВИД-19 цар тархалтын улмаас сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах зайлшгүй шаардлага гарч их дээд сургуулиудын сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн энэ үед сургалтын чанарыг оюутны өөрийн үнэлгээ, сэтгэл ханамжийг судлах нь сургалтын чанарыг сайжруулахад чухал юм. Цахим сургалтын талаарх оюутны өөрийн үнэлгээ, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлоход зорилгын хүрээнд тоон судалгааны асуумжийн аргыг ашиглаж, нийт АШУҮИС-ийн 3153 оюутныг хамруулав. АШУҮИС-ийн арван оюутан тутмын ес нь цахим хичээл хуваарь, цаг баримтлах байдал, хөтөлбөрийн дагуу хичээл орж буй байдал, хичээлийн агуулгыг тодорхой, ойлгомжтой гэж үнэлж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь курсээр ялгаатай байна. АШУҮИС-ийн арван оюутан тутмын долоо нь цахим хичээлд багш үзүүлэн, таниулах материал сайн ашигладаг, хичээлээр онолын мэдлэгээ бататгадаг, багштай эргэх холбоотой харилцаж чаддаг байна. Оюутнуудын цахим сургалтын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин өндөр ба сэтгэл ханамжийн түвшин болон курс урвуу хамааралтай байна, салбар, бүрэлдэхүүн сургуулиар авч үзэхэд ялгаагүй байв.

Үндэслэл

Анагаах ухааны боловсролын хөгжлийн үндсэн чиглэл нь цахим сургалт болж байна (Д.Амарсайхан, 2018). Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ байдаг (Ц.Лхагвасүрэн, 2021). Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах зайлшгүй шаардлага КОВИД-19 цар тархалтын улмаас их дээд сургуулиудын сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн энэ үед сургалтын чанарыг сайжруулахад оролцогч талуудын үнэлгээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Короновируст халдварын улмаас Иймээс цахим сургалтад оюутны үнэлгээг судлах шаардлагатай.

Зорилго, зорилт

Цахим сургалтын талаарх оюутны өөрийн үнэлгээ, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлоход зорилгын хүрээнд цахим сургалтын талаарх оюутны өөрийн үнэлгээний түвшинг тодорхойлох, цахим сургалтын талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох зорилтуудыг дэвшүүлэв.

Арга аргачлал

Судалгааг агшингийн судалгааны асуумжийн аргаар 2020 оны 12 дугаар сард АШУҮИС-ийн Цахим сургалтын системийг ашиглан явуулсан ба 7500 орчим оюутны имэйл хаягаар асуумжийг илгээсэн. Асуумжийг хариулах түвшин (response rate) 42 хувь байв.

Үр дүн

Судалгаанд АШУҮИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургуулийн нийт 3153 оюутан хамрагдсан бөгөөд курсээр авч үзвэл нэгдүгээр курс 40.3 хувь, хоёрдугаар курс 18.8 хувь, гуравдугаар курс 16.9 хувь, дөрөвдүгээр курс 12.5 хувь, тавдугаар курс 7.3 хувь, зургаадугаар курс 4.2 хувийг эзэлж байв. Цахим хичээл байнга хуваарийн дагуу ордог гэж судалгаанд оролцогчдын 85.6 хувь, дунд зэрэг 11.7 хувь нь хариулсан бөгөөд курсээр авч үзвэл курс багасах тусам хуваарийн дагуу

хичээл орж буй байдал өндөр байна (p≤001). Цахим хичээлийн багш цагийг баримталдаг гэж 86.9 хувь нь хариулсан ба курсээр ялгаатай байна (p≤001). Харин цахим хичээлийн шууд холболт (real-time) холбогдох хугацааг нэг цагаас дээш үргэлжилдэг гэж 68.7 хувь нь хариулсан ба нэг цагаас бага хугацаанд үргэлжилдэг гэж 31.3 хувь нь хариулжээ.

Цахим хичээл хөтөлбөрийн дагуу ордог гэж оюутнуудын 98.9 хувь нь үзсэн бол хичээлийн агуулга ойлгомжтой, тодорхой байдаг гэж 97.2 хувь нь хариулсан байна. Цахим хичээлд багш үзүүлэн, таниулах материал ашиглах байдлыг сайн гэж 70 хувь, дунд зэрэг гэж 22.6 хувь, муу гэж 1.6 хувь, хичээлээр онолын мэдлэгээ батагаж, дэлгэрүүлж ойлгож бүрэн чаддаг гэж 65.5 хувь, дунд 28.8 хувь, чаддаггүй гэж 5.8 хувь нь хариулсан. Цахим семинар, дадлагын үед багштай эргэх холбоотой харилцаж бүрэн чаддаг гэж 69.1 хувь, дунд зэрэг гэж 24.7 хувь, чаддаггүй гэж 6.2 хувь нь үзжээ. Цахим хичээлийн үед багш нар оюутны мэдлэгийг бодитой үнэлдэг гэж 70.4 хувь, дунд зэрэг гэж 24.9 хувь нь хариулжээ. Оюутнуудын цахим сургалтын ерөнхий сэтгэл ханамжийг авч үзвэл 86 хувь нь сэтгэл ханамжтай, 14 хувь нь сэтгэл ханамжгүй байна. Цахим сургалтын сэтгэл ханамж бага курсынханд илүү өндөр байна (p≤001).

Хэлцэмж

Судлаач Калдон нарын 2021 онд хийгдсэн Их сургуулийн оюутнуудын цахим сургалтын талаарх сэтгэл ханамжийг тоон судалгааны асуумжийн аргаар судалсан судалгаанд оюутнуудын сэтгэл ханамж дундаас доогуур үр гарсан. Мөн тус судалгаанд сэтгэл ханамжид курсын түвшинээр ялгаагүй байжээ (Khaldoun Mohammad Hamdan, 2021). Бидний судалгаанд сэтгэл ханамжийн түвшин дундаас дээгүүр байсан ба курс багасах тусам сэтгэл ханамж өндөр байв. Харин судлаач Адис нарын 2021 онд хийсэн судалгаагаар Цахим сургалтын талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаанд орчны болон нийгмийн хүчин зүйлс хамааралгүй (Adis Puka, 2021) байсан бол бидний судалгаанд мөн харьяалагдаж буй сургууль, мэргэжлийн үзүүлэлтүүд хамааралгүй байв.

Дүгнэлт

АШУҮИС-ийн арван оюутан тутмын ес нь цахим хичээл хуваарь, цаг баримтлах байдал, хөтөлбөрийн дагуу хичээл орж буй байдал, хичээлийн агуулгын тодорхой, ойлгомжтой гэж үнэлж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь курсээр ялгаатай байна. АШУҮИС-ийн арван оюутан тутмын долоо нь цахим хичээлд багш үзүүлэн, таниулах материал сайн ашигладаг, хичээлээр онолын мэдлэгээ бататгадаг, багштай эргэх холбоотой харилцаж чаддаг байна. Оюутнуудын цахим сургалтын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин өндөр ба сэтгэл ханамжийн түвшин болон курс урвуу хамааралтай байна, салбар, бүрэлдэхүүн сургуулиар авч үзэхэд ялгаагүй.

Ном зүй

1. *Adis Puka, E. P. (2021). Students' Satisfaction with E-learning Platforms in Bosnia and Herzegovina. Technology, Knowledge and Learning volume , 173-191.*
2. *Khaldoun Mohammad Hamdan, A. M.-B.-D.-H. (2021). University students' interaction, Internet self-efficacy, self-regulation and satisfaction with online education during pandemic crises of COVID-19 (SARS-CoV-2). International Journal of Educational Management, 354.*
3. *Д.Амарсайхан, Э.Ренчиндорж (2018). Цахим сургалт. Бүлэг, Ц.Лхагвасүрэн, Н.Сүмбэрзул, Д.Цэрэндагва, Б.Оюунгоо, Д.Отгонбаяр, Анагаах ухааны боловсрол судлал (pp. 146-166). Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.*
4. *Ц.Лхагвасүрэн, О.Болорсайхан (2021). Монгол улсад эмч бэлтгэх анагаах ухааны боловсролын хөгжил, шинэ үзэл баримтлал. Улаанбаатар: «Эрхэс» хэвлэх үйлдвэр.*

Students' Self-Evaluation and satisfaction with E-learning during pandemic crisis of COVID-19

Khandmaa.S, Ser-Od.Kh[2], Baljinnyam.B[1], Gal-Erdene.S[1], Javkhlan.B[3], Nyamdorj.D[4] Batbaabar.G[5]
[1]Division for faculty development and e-learning, MNUMS
[2]School of public health, MNUMS
[3]Division for undergraduate training policy and management, MNUMS
[4]School of Biomedicine, MNUMS
[5]MNUMS
khandmaa@mnums.edu.mn

ABSTRACT

University trainings have transferred into e-learning due to COVID-19 pandemic for last few months. At this time, it is necessary to determine student's self-evaluation and satisfaction towards e-learning for assuring quality of trainings as a factor of curriculum evaluation. Aims of survey was to determine level of self-evaluation and satisfaction towards e-learning among MNUMS students. A total of 3153 students were responded to our email survey. Results show that nine out of ten students were evaluated with high score for class scheduling, timing, according to syllabus, and, comprehensibility of teachings while it differs with levels of years. Seven out of ten students were satisfied with teaching tools, strengthening their own knowledge during online class, well interacting with faculties, such as feedback. General satisfaction of students was high while there is indirect relationship between satisfaction and level of years. There was no statistical significance between satisfaction and schools.